

## Бидний чадамж

- Германы болон олон улсын үйлдвэрлэлийн салбар дахь удирдлагын арвин туршлага
- Удирдах албан тушаалтнууд, мэргэжилтнүүд болон уул уурхайн инженерүүдтэй удаан хугацаанд хадгалж ирсэн хамтын ажиллагаа
- Олон улсын уул уурхайн төслүүд (Монгол улс, Чех, Колумб, Казакстан, Вьетнам, Лаос, Тайланд)

## Бидний ажиллах аргачлал

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг болон байгаль орчныг хамгаалах зорилготой аливаа үйл ажиллагаа нь үйлдвэр, уурхайн цөм процессийг дэмжиж байх ёстой.

Энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд хэрэглэгчид чиглэсэн, үйлдвэр бүрийн өвөрмөц онцлогт тохируулсан шийдлүүдийг танд санал болгох юм. Амжилтанд хүрэх замд таны ойрын туслагч тань бид байх болно.

Нөхцөл байдлын шинжилгээ хийх

Потенциалийг тодорхойлох

Шийдлийг олох

Арга хэмжээг нэвтрүүлэх

Амжилтанд хүрэх

## Бидний үр дүн

- Танай байгууллагын эдийн засгийн өрсөлдөх чадвар өсөн нэмэгдэнэ
- Процесс болон үйл ажиллагааны бүтэц сайжирна (байгууллагын стандарт)
- Эрүүл, аюулгүй ажлын байр бий болно
- Таны ажилтнуудын ажлын бүтээмж, идэвх санаачлага, сэтгэл ханамж нэмэгдэнэ
- Стандартчилал (OHSAS 18001/ISO 45001, ISO 14001 und ISO 9001)

## Холбоо барих

(Монгол, Англи, Герман хэлээр холбогдох боломжтой)

### Mathias Bauer, Prof. Dr.-Ing. habil. Dr. h.c.

Утас: +49 6826 510 910

E-Mail: [bauer@cbm-ac.de](mailto:bauer@cbm-ac.de)

### Jan Schiffer, Dipl.-Ing. /M. Sc., HSE-Engineer

Утас: +49 241 8949 8852

E-Mail: [schiffer@cbm-ac.de](mailto:schiffer@cbm-ac.de)

### Бямба овогтой Эрдэнэбаатар М. Sc., Маркшейдер, Эрдэс баялгийн инженер,

Утас: +49 241 8949 9854

E-Mail: [byamba@cbm-ac.de](mailto:byamba@cbm-ac.de)

## CBM GmbH

Gesellschaft für Consulting,  
Business und Management mbH

### Төв байр

Niederbexbacher Str. 67

66450 Bexbach

Утас: +49 6826 510910

Fax: +49 6826 524263

[www.cbm-ac.de](http://www.cbm-ac.de)

### Салбар

Horngasse 3

52064 Aachen

+49 241 8949 8852

+49 241 8949 8854

[www.cbm-hse.com](http://www.cbm-hse.com)



**БАЙГУУЛЛАГЫН АМЖИЛТЫН  
ҮНДЭС — УДИРДЛАГЫН  
НЭГДСЭН ТОГТОЛЦОО**

Аюулгүй байдал.  
Амжилтын хөшүүрэг.

## Бидний тухай

ХБНГУ-ын СВМ нь 2000 онд байгуулагдсанаас хойш Уул уурхайн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын салбарт амжилттай ажиллаж байгаа арвин туршлагатай компани юм.

Бид ашиглалтын технологи, эдийн засаг, хөдөлмөрийн аюулгүй байдал болон байгаль орчныг хамгаалах хүрээнд хайгуулаас эхлээд уурхайн хаалт хүртэл үе шат бүрт аж ахуйн нэгжийн бүхий л түвшинд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. Манай зөвлөгч нар уул уурхайн үйлдвэрлэлийн салбарт олон жилийн турш удирдах түвшинд ажиллаж байсан туршлагатай.

Үйл ажиллагааны чиглэл:

- ХАБЭА болон Байгаль орчныг хамгаалах,
- Хүний нөөцийн хөгжил болон
- Олон улсын уул уурхайн зөлөлгөө / түүхий эдийн боловсруулалт болон баяжуулалт

## Монгол дахь үйл ажиллагаа

- Анх 2012 онд монголын нэгэн уул уурхайн компанид ХАБЭА – н төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн
- 2013 оноос хойш Монгол-Германы ашигт малтмал технологийн их сургуулийг (GMIT) үдэслэн байгуулах үйл явцад зөвлөх үйлчилгээ үзүүлж байна
- 2013 оноос хойш манай ажилтнууд олон чуулган, форумд төрөл бүрийн илтгэл тавьж оролцож байна
- 2014 онд „Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлэх аргачлал“ нэртэй гарын авлага бичиж хэвлүүлсэн
- 2014 оноос хойш УУҮА-тай хамтран ХАБЭА –н ажилтны мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж төслийн хүрээнд сургалтыг явуулж байна

## Бидний үйл ажиллагаа

Сүүлийн жилүүдэд Монголын засгийн газар уул уурхайн компаниудаас нийгмийн болон байгаль орчны хүрээнд хариуцлагатай уул уурхайн үйлдвэрлэлийг хэрэгжүүлэхийг шаардаж байгаа билээ.

Таны аж ахуй нэгж эрүүл, аюулгүй ажлын байрыг бий болгох үүний зэрэгцээ эдийн засгийн хувьд өрсөлдөх чадвартай байгууллага болж хөгжихөд бид тантай хамтран ажиллаж, зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.

Удирдлагын тогтолцоог хөгжүүлэх, нэвтрүүлэх нь бидний нэг үндсэн үйл ажиллагаа бөгөөд СВМ нь германы болон олон улсын төслийн арвин туршлагадаа тулгуурлан **Хөдөлмөрийн аюулгүй байдал** болон **байгаль орчныг хамгаалах** үйл ажиллагааг орхигдуулахгүйгээр үйлдвэрлэлийн **бүтээмж, бүтээгдэхүүний чанарыг** урт хугацаанд тогтвортой сайжруулах, сул зардлыг хэмнэх арга хэмжээг нарийвчилсан шинжилгээний үр дүнд үндэслэн санал болгох, зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.

### Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

- Процесс-д тулгуурласан хөдөлмөрийн аюулгүй байдлын үзлэг
- SCC–Certificate -н итгэмжлэлд бэлтгэх
- Удирдлага болон удирдах албан тушаалтнуудыг сургах
- Техник технологийн өөрчлөлтийн үе шат бүрт тохирсон зөвлөх үйлчилгээ
- Цахим технологид түшиглэсэн ХАБЭА-ийн багаж хэрэгслүүдийг (програм хангамж) нэвтрүүлэх. (эрсдэлийн үнэлгээ, тайлан, ослын акт, ослын дүгнэлт, KPI, ажлын байрны зааварчилгаа, хорт бодисын кадастр болон гэрээт ажил гүйцэтгэгчдийн удирдлага гэх мэт)

## Байгаль орчныг хамгаалах

- Төлөвлөсөн болон хэрэгжиж байгаа уул уурхайн төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг тооцоолох, үнэлгээ хийх
- Уурхай болон үйлдвэрлэлтээс ялгарч буй хорт утаа, тоос болон бусад бодисыг багасгах арга хэмжээ авах, хяналт тавих
- Усны хэрэглээний сайжруулсан удирдлага
- Уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн газрын нөхөн сэргээлт болон цаашдын хэрэглээний концепт боловсруулах

## Бүтээмж, бүтээгдэхүүний чанар

- Өндөр бүтээмжтэй олборлолт болон үйлдвэрлэлийн технологийг бий болгох, сайжруулалтад зориулсан стандартуудыг хөгжүүлэх үеийн техникийн болон зохион байгуулалтын зөвлөгөө өгөх
- Өөрийн үйлдвэр, уурхайд хамгийн сайн тохирсон шинэ технологи болон тоног төхөөрөмж худалдаж авахад санал зөвлөгөө өгөх
- Үйлдвэрийн аюулгүй байдлын тоног төхөөрөмжид үзлэг хийж шалгах, Осол эндэгдэлээс сэргийлэх арга хэмжээг авах. (далд уурхайн агааржуулалтын сайжруулалт, дэлбэрэлтээс хамгаалах, мөргөцгийн аюулгүй байдал)
- Удирдлагын нэгдсэн тогтолцоо (OHSAS 18001 / ISO 45001, ISO 14001 und ISO 9001)



Мэргэшүүлэх сургалт болон удирдлагын тогтолцооны талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах

